



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

「 ХУШААТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД

2024.08.07 № ТНАТ-2024/13-УТА-НА-15
танай _____-ны № _____-т

「 Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020933

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хушаат сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (.5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хушаат сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024-2028

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**ХУШААТ СУМ
2024 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ**

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.06.15.



**ХУШААТ САЙХАН НУТГАА
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ”**

Монгол Улсын хөгжлийн Алсын харааг үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн зорилтууд, Сэлэнгэ аймгийн Монгол Ардын Намын хорооноос Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх, Хушаат нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор сумын ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумынхаа нийгэм эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Хушаат сумын Монгол Ардын Намын хорооноос 2024-2028 онд Хушаат нутгийнхаа хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл иргэн-Амьдралын суурь

- 1.1 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, үзлэгт иргэдээ тогтмол хамруулж, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.
- 1.2 “Элэг бүтэн Монгол”, “Хавдаргүй Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Эрүүл хүүхэд” хөтөлбөрүүдэд иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.3 Иргэн бүрийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.4 Иргэн бүрийг 2 жилд 1 удаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 1.5 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлдэгт хамруулна.
- 1.6 Эмч, эмнэлгийн ажилтнуудыг орон сууцаар хангах ажлыг хэрэгжүүлэх, залгамж халааг бэлтгэн амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.7 Орон нутагт өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад олгох урамшуулал, дэмжлэгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.8 Эрүүл мэндийн төвд үзүүлэх анхан шатны тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, түргэвчилсэн оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийн чанарыг дээшлүүлнэ.
- 1.9 Сумын эмийн сангийн эмийн чанар, хүртээмж, үнийн нэмэгдэлд хяналт тавина.
- 1.10 Малчдын эрүүл мэндийн байдалд онцгой анхаарч, эрүүл мэндийн явуулын үйлчилгээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ

Боловсролтой иргэн-Хөгжлийн суурь

- 2.1 Бага дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж, эцэг эхчүүдэд танилцуулж, үнэлүүлдэг болно.
- 2.2 Боловсролын шинэчилсэн хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсны дагуу сумын ЕБС-д англи хэлийг эзэмшихэд мэргэжлийн багшийг урьж ажиллуулан амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 2.4 Багшийг орон сууцаар хангах бодлого барьж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, өмчлүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5 Орон нутагт дутагдалтай мэргэжлээр өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах багшид дэмжлэг үзүүлнэ.
- 2.6 Орон нутагт дутагдалтай багш мэргэжлээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Хушаат сумын харьяат оюутныг дэмжин ажиллана.
- 2.7 Хүүхэд багачуудыг улс, аймгийн болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.8 Насан туршийн боловсрол олгох төвийн хамран сургалт, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 2.9 Сумын хүүхэд багачуудыг хөдөлмөрт сургах чиглэлээр “Зуны хөдөлмөр зуслан” сургалтыг зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГ

Соёлтой иргэн-Ёс суртахууны суурь


- 3.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд соёлч Монгол иргэнийг сургаж, төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2 “Соёлч иргэн”, “Соёлч өрх”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд улиралд соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурин соёлыг дэлгэрүүлнэ.
- 3.3 Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 3.4 Номын сан, орон нутаг судлах танхимыг байнгын ажиллагаатай болгож үзмэр, сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээ, сурталчилгааны чанарыг дээшлүүлнэ.
- 3.5 Хүүхэд, залуучууд, ахмадууд, уран бүтээлчдийг соёл урлагийн чиглэлээр улс, аймгийн болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.
- 3.6 Хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЕЙН ТАМИР СПОРТ

Эрүүл, чийрэг иргэн-Идэвхтэй амьдрал

- 4.1 Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх, сайжруулах, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг дэмжиж ажиллана.
- 4.3 “Сэлэнгэ лиг” спортын олон төрөлт тэмцээнд сумын хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

- 4.4 Сумын ард, иргэдийн дунд спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 4.5 Тамирчдыг улс, олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцоход зохих дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.
- 4.6 “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг “Би эр хүн” олон төрөлт тэмцээнийг өргөжүүлж зохион байгуулна.



ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН
Сэтгэл тайван иргэн- Аз жаргалтай амьдрал

- 5.1 Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын төвд холбогдох хууль, дүрэм журам, норм, стандартыг мөрдүүлнэ.
- 5.2 “Тэр бум мод”, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 5.3 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, дахивар хог хаягдал худалдан авах цэг байгуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.
- 5.4 Суманд аюултай хог хаягдал түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр үе шаттайгаар байгуулна.
- 5.5 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 5.6 Хушаат сумын төвд мах, сүү, төмс, хүнсний ногоо, цагаан идээ боловсруулах “Хушаатад үйлдвэрлэв” худалдааны цэг байгуулна.
- 5.7 Гамшигт үзэгдлүүд /ган, зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга, үер, гал түймэр г.м/-ийн тархалт, давтамж, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.8 Сумын төвийн айл өрхүүдийн хог хаягдлыг тогтмол хуваарийн дагуу тээвэрлэн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгуулна.
- 5.9 Сумын төвийн ундны усны цэгүүдийг байнгын ажиллагаатай буюу ухаалаг худгийн систем тавих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.10 Сумын төвийн айл өрхүүдийн хашааг шинэчлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 5.11 Сумын төвийг бүрэн камержуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.12 Сумын төвийн гэр хорооллын нүхэн жорлонг сайжруулах, хөрсний бохирдолгүй ЭКО 00 болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
Хөдөлмөрч иргэн- Элбэг хангалуун амьдрал

- 6.1 Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнес эрхлэх, ур чадварыг хөгжүүлэх, өрсөлдөх хэмжээнд чадварыг дээшлүүлж ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 6.2 Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 6.3 Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.4 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих зорилгоор хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгосон төсөл хөтөлбөрүүдэд хяналт тавьж ажиллана.
- 6.5 Иргэдэд нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт үйлчилгээ эрхлэх боломжийг олгоно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 7.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоотой, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.2 Гэр бүлийн хүчирхийлэл, үе тэнгийнхний хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.3 Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч сум болно.
- 7.4 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх боломжийг бүрдүүлнэ.
- 7.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж үйлчилгээний асуудалд анхаарч энэ чиглэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 8.1.1 Аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг сайжруулж хөгжүүлнэ.
- 8.1.2 Ар могойн рашааныг түшиглэсэн амралт, сувилал байгуулах сумын иргэн, ААН, байгууллагын саналыг дэмжиж ажиллана.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 8.2.1 Хүнсний нарийн ногоо болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ төрлийн таримал ургамлын тариалалт хийх хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 8.2.2 Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулна.
- 8.2.3 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.
- 8.2.4 Төвлөрсөн хүлэмжийн ашиглалтыг сайжруулж өвлийн хүлэмжтэй болох боломжийг бүрдүүлнэ.
- 8.2.5 Төмс хүнсний ногоо тариалагчдад үйлчлэх дундын техникийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайруулна.

МАЛ АЖ АХУЙ

- 8.3.1 Сумын хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, үржлийн ажлыг сайжруулна.
- 8.3.2 Мал, амьтны өвчний гаралт, тархалтад хяналт тавих, хариу арга хэмжээг эрчимжүүлж сумын түвшинд халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулна.
- 8.3.3 Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН

- 9.1 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомсдол, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 9.2 Сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнын тархцын судалгааг явуулж бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.
- 9.3 Хууль бус ан агнуур, модны хулгайг таслан зогсоож байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

- 9.4 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 9.5 Байгалийн дагалт баялгийн ашиглалтад хяналт тавина.



АРАВДУГААР БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ

Иргэнд ойрхон - төрийн үйлчилгээ

- 10.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 10.2 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж төрийн хүнд суртлыг арилгана.
- 10.3 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, захирамж, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 10.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн байгууллагуудад тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж мэдээллийг ил тод, шилэн байлгана.
- 10.5 Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.
- 10.6 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 10.7 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 11.1 Сумын төвийн замыг Дархан Сэлэнгийн авто замтай холбох саналыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 11.2 Сумын төвийн гудамжнуудын гэрэлтүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлэн, засварлана.
- 11.3 Сумын Соёл спортын нэгдсэн төвийн зураг төсвийг хийлгэж, санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 11.4 Сумын ЗДТГ-ын шинэ байрны зураг төсвийг хийлгэж, санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 11.5 Музейн шинэ байрын зураг төсвийг хийлгүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг улс, аймгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 11.6 Ахмадын өргөөний зураг төсвийг хийлгүүлж, санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 11.7 Сумын ЕБС-ийн спортын талбайн аюулгүй таатай орчныг бүрдүүлнэ.

Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван сум болно.

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын МАН-ын Хорооноос 2024 оны Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлэх, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Хушаат сайхан нутгаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЕ".

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО